

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2023/12/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг

2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК

Утас:99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46063
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.09 № 27

талай _____ -ны № _____ -т

ГОВИЙН БАГА ДАРХАН ЦААЗАТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА Ч.БАТСҮХ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгаль, зэрлэг амьтадыг хамгаалах нийгэмлэгээс "Smart" хяналт шалгалтын төслийг хэрэгжүүлснээр дархан цаазат газар нутагт хэрэгжүүлэх хяналт, шалгалт сайжирсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 6/6 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу 13.2 сая төгрөгийн хог хаягдлын хураамжийн орлого төвлөрүүлдэг болсон нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нөлөөтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

015820023

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	35.7	38.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	247.3	217.5
Нийт хөрөнгийн дүн	283.0	256.0
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	283.0	256.0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	283.0	256.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	448.1	430.1
Үйл ажиллагааны зардлын дүн	419.4	457.1
Үйл ажиллагааны үр дүн	28.7	(27.0)
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	28.7	(27.0)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254.3	283.0
Тайлант оны үр дүн	28.7	(27.0)
Эцсийн үлдэгдэл	283.0	256.0
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	384.4	420.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	384.4	420.1
Үйл ажиллагааны ЦМГ	-	-
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	347.7	307.9
Урсгал зардал	347.7	307.9
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	347.7	307.9
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Орон нутгийн төсвөөс санхүүжих	345.6	305.8
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2.1	2.1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа илрээгүй тул залруулга хийгдээгүй, нийт 2 зөрчил¹ илэрснээс, 2 заалт бүхий зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хур мэдээллийн системээс тухайн байгууллагын эзэмшилд байгаа газрыг хянахад 2020 онд гэрчилгээ нь тус байгууллагын эзэмшүүлэхээр гарсан 750 м.кв ажилчдын байрны зориулалттай 15 жилийн хугацаатай газрыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 “*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ*” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг баримтлан ажиллаж тус байгууллагын эзэмшүүлэхээр гэрчилгээ нь гарсан газрыг үнэлэн данс бүртгэлд тусгах

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг төлөхдөө E barimt цахим системээс нэхэмжлэхээр ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна. Нэхэмжлэхийг төлбөрийг төлсөн боловч харилцагч байгууллага нь нэхэмжлэхээ хааж төлбөрийн баримт үүсгээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу төлбөрийг төлсний дараа тухайн байгууллагаасаа нэхэмжлэхийг хаалгаж баримтыг авч Татварын ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга хийгдээгүй												

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дүн												
-----	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим төлбөрийн баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн	1	0					1	0				
Газар үнэлж данс бүртгэлд тусгаагүй	1	0					1	0				
Дүн	2	0					2	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

